

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



Ц.ТУЛГА

“ТУУЛ ГОЛ ДАГУУ АМРАЛТ, ЗУГААЛГЫН ЦОГЦОЛБОР” БАЙГУУЛАХ КОНЦЕПЦ, ЗАГВАР ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

НЭГ. ЕРӨНХИЙ АГУУЛГА

1. ЗОРИЛГО

Иргэд олон нийтийн амрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн, орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан “Амралт зугаалгын цогцолбор” байгуулах концепц, загвар зураг боловсруулах шийдлийг тодорхойлох.

2. УРАЛДААНД ОРОЛЦОГЧ

- Зураг төслийн мэргэжлийн байгууллага;
- Хувь хүн, мэргэжлийн уран бүтээлчид;

3. ХУГАЦАА

Уралдааныг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэл явагдана.

4. АЖЛЫН БҮРДЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Өгөгдсөн 5 байршлын онцлогийг харуулж уялдаа холбоотой төлөвлөх.
- Зураглалыг загвар зургийн ерөнхий шаардлагын дагуу боловсруулах.
- Зураглалын иж бүрдэл А3 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр ирүүлэх. (*.dwg, *.pdf, *.jpg, *.max)
- Тайлбар бичиг, танилцуулга А4 формат, хэвлэмэл болон файл хэлбэрээр ирүүлэх. (*.doc, *.pdf, *.ppt)

5. ЗОХИОГЧИЙН ЭРХ

- Шилдгээр шалгарсан бүтээлийн зохиогчийн эрх нь уралдаан зарласан захиалагч байгууллагын талд үлдэх ба цаашид ашиглах, хөгжүүлэх онцгой эрх захиалагч байгууллагад хадгалагдана.
- Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж олгохгүй бөгөөд захиалагч байгууллагын архивд үлдэнэ.

6. МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ

- Уралдаанд оролцох материалыг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 10:00 - 16:00 цагийн хооронд дараах хаягаар хүлээн авна.
Хот байгуулалт, хөгжлийн газар (Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Нийслэлийн Засаг захиргааны II байр, Хангарди ордон, 13 давхрын 1302 тоот)

7. ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ

- UTM 1:500 байр зүйн зураг 5 байршилд файл хэлбэрээр (*.dwg)
- Ажлын даалгавар (батлагдсан)

8. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар;
- Хот байгуулалт, хөгжлийн газар;

ХОЁР. ШАЛГАРУУЛАЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

9. ШАЛГАРУУЛАЛТ

Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон уралдааныг дүгнэх үүрэг бүхий комиссын гишүүд уралдаанд ирүүлсэн бүтээлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1.	Төслийн үзэл санаа, шинэлэг байдал	20
2.	Иргэд олон нийтийн амрах нөхцөлийг бүрдүүлсэн байх	20
3.	Байгаль орчинд ээлтэй, орчин үеийн технологийн шийдэл тусгасан байдал	20
4.	Ажлын гүйцэтгэл, иж бүрдлийн шаардлагыг хангасан байдал	20
5.	Олон нийтийн санал	20
	Нийт	100

10. ОЛОН НИЙТИЙН САНАЛ

- Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдийн хооронд www.uda.ub.gov.mn сайтад байршуулан санал авна.

11. ШАГНАЛЫН САН, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Нийт шагналын сан: 20.000.000 (хорин сая) төгрөг

- Тэргүүн байр: 15.000.000 (арван таван сая) төгрөг;
- Дэд байр: 5.000.000 (таван сая) төгрөг;

ГУРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Оролцогчид дараах асуудлын хүрээнд гомдол гаргаж болох бөгөөд бусад асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч хэлэлцэхгүй.

- Зохиогчийн эрх зөрчигдсөн асуудлаар (*Хувь хүн болон байгууллагын бүтээлийг хуулбарлаж оролцсон*);
- Уралдааныг дүгнэх комиссын бүрэлдэхүүнд багтсан гишүүнтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдсэн үед;

Гомдлыг шилдэг бүтээл шалгарч зарласнаас хойш 1 хоногийн дотор бичгээр үйлдэж зохион байгуулагчид хүргүүлнэ. Хугацаа хожимдсон болон гомдол гаргасан үндэслэлээ баталгаажуулж хавсаргаагүй гомдлыг хүлээж авахгүй.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Хот байгуулалт, хөгжлийн газар (Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Ц.Жигжиджавын гудамж-7/1, Хангарди ордон, 13 давхар, 1302 тоот) 11-321943 утсаар болон www.uda.ub.gov.mn сайтаас;

ХЯНАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.БАТТӨМӨР

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН



С.ВАНДАНДОРЖ